



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/358

Хэрлэн сум


Хог хаягдлын хураамжийн ажилд
зориулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалтыг ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Айл өрхүүдийн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгаан эрчим хүчний төлбөртэй хамтатган хураан төвлөрүүлэх зорилгоор тооцооны программд сумдыг холбох, өөрчлөлт оруулах ажилд 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2 Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас ажил гүйцэтгэх гэрээний дагуу санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ